

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТОВЧ ТАЙЛАН

(Иргэд, олон нийтэд зориулсан хувилбар)

Хяналт-шинжилгээ хийх үндэслэл



Төрийн байгууллага жил бүр өөрийн ажлын төлөвлөгөө хэрхэн биелж байгаа, иргэдэд үзүүлж буй үйлчилгээ сайжирсан эсэхийг дүгнэдэг. Энэ хүрээнд 2025 оны хагас жилийн ажлын гүйцэтгэлийг тогтоосон журмын дагуу шалган дүгнэв.

Хяналт-шинжилгээний зорилго



Тамгын газрын 2025 онд төлөвлөсөн ажил хагас жилийн байдлаар бодитоор биелсэн эсэхийг нягтлан шалгах;
Хэрэгжилт хангалтгүй бол шалтгааныг тодруулах;
Удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах,
Цаашид сайжруулах санал гаргах.

Үнэлгээг хэрхэн хийсэн бэ?

Бичиг баримт, төлөвлөгөөний биелэлтийг нягтлан судалж, хариуцсан ажилтнаас мэдээлэл, тайлан авч,, Засгийн газраас баталсан журамд заасан аргачлалын дагуу үнэлж, хэрэгжилтийн хувийг гаргав.

Үнэлгээгээр гарсан үр дүн




2025 оны эхний хагас жилд Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө 94.4%-ийн биелэлттэй гэж дотоод хяналтаар үнэллээ.



- Бүрэн хэрэгжсэн 59.4%
- Хангалттай хэрэгжсэн 5.2%
- Хэрэгжилт хангалтгүй 5.2%
- Хугацаа болоогүй 20.8%
- Хойшлуулсан 9.4%

Төлөвлөгөөний 5 зорилтын хэрэгжилт

- Хэрэгжилтийн хувь
- Хэрэгжээгүй хувь



Төлөвлөгөөний зорилтууд өндөр хэрэгжилттэй байгаа боловч зарим ажлыг хугацаанд нь хэрэгжүүлэх, хойшлогдсон болон хангалтгүй гүйцэтгэлтэй арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмж



- Хугацаандаа биелээгүй болон хангалтгүй хэрэгжилттэй 14 арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд багтаан хэрэгжүүлэх;
- Тайлангийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтэд тулгуурлан бодитоор гаргах;
- Хэрэгжээгүй арга хэмжээний шалтгаан, нөхцөлийг тодорхой гаргаж ил тод мэдээлэх.